



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20<sup>2022</sup> он <sup>03</sup>  
сарын 11 өдөр

Дугаар 31-1/40

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000007



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>дд</sup> он <sup>д</sup> дугаар  
сарын <sup>18</sup>-ны өдөр

Дугаар <sup>1081</sup>/125

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>9</sup> хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225000017



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@tojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022 01. 12 № 1/238

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА**

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу боловсруулсан Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Хавсралт ... хуудастай.



Х.НЯМБААТАР

А5 Файл.2022  
1515 10215



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2022.01.14 № 13-2/196

танай \_\_\_\_\_-ны № 1/239 -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА**

Зарим төрлийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.



**Б.ЖАВХЛАН**

**9761000112**



## ЗАРИМ ТӨРЛИЙН ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

#### 1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

#### 1.2.Практик шаардлага:

Төрийн хяналт шалгалтын улмаас хүнд суртал нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд дарамт учирч байна гэсэн ойлголт олон нийтийн дунд түгээмэл байгаа нь олон удаагийн судалгаа, тэдгээрээс гарсан дүгнэлтэд дурдагдсан байдаг.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх үүднээс бизнес эрхлэлтийг дэмжих, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

### Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчлэх хууль тул түүнд тусгагдсан зохицуулалтууд нь түр хугацаанд үйлчлэх шинжтэй юм. Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор 3 жилийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхгүй бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэр байгаа тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхээр заасан.

Мөн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд зөрчил илэрсэн бол тэргүүн ээлжинд зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлнэ. Түүнчлэн энэ хуулийн үйлчлэх хугацаа дууссан нь төрийн хяналт шалгалтыг нөхөж хийх үндэслэл болохгүй.

Энэ хуулийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг зогсоох, үйл ажиллагааг шууд

зогсоохоос бусад төрлийн зөрчилд тэргүүн ээлжид зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлэх тухай зохицуулалт нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, гааль, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас хийх хяналт шалгалтад хамаарахгүй.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төсөл батлагдсанаар энэ хуулийн үйлчлэх 3 жилийн хугацаанд бизнес эрхлэгчид болон иргэнд хяналт шалгалтын улмаас учирч буй дарамтыг хөнгөвчлөн, тэдгээрт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг хяналт шалгалтын эрх зүйн орчин бүрдэнэ.

Хяналт шалгалтын үр дүнд торгууль ногдуулах бус, эхлээд зөвлөн туслах шинжтэй албан шаардлага хүргүүлэх нь хяналт шалгалтын байгууллага иргэдэд илүү ойр байж, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, туслах, дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн тухай**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

## ТАНИЛЦУУЛГА

*Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийн талаар*

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын 4 дүгээр хавсралтаар тус бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтыг баталсан. Үүний дотор Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан байна.

Төрийн хяналт шалгалтын улмаас хүнд суртал нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд дарамт учирч байна гэсэн ойлголт олон нийтийн дунд түгээмэл байгаа нь олон удаагийн судалгаа, тэдгээрээс гарсан дүгнэлтэд дурдагдсан байдаг.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэхэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг түр хугацаанд зогсоох нь бизнес эрхлэгчдэд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байгаа тул энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчлэх юм. Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор 3 жилийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхгүй бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллээр, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэр байгаа тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхээр заасан.

Мөн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд зөрчил илэрсэн бол тэргүүн ээлжинд зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлнэ. Түүнчлэн энэ хуулийн үйлчлэх хугацаа дууссан нь төрийн хяналт шалгалтыг нөхөж хийх үндэслэл болохгүй.

Энэ хуулийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг зогсоох, үйл ажиллагааг шууд зогсоохоос бусад төрлийн зөрчилд тэргүүн ээлжид зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлэх тухай зохицуулалт нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, гааль, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас хийх хяналт шалгалтад хамаарахгүй.

Энэ хууль нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхийг зогсоохгүй.

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төсөл батлагдсанаар энэ хуулийн үйлчлэх хугацаанд бизнес эрхлэгчид хяналт шалгалтын улмаас учирч буй дарамтыг хөнгөвчлөн, тэдгээрт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг хяналт шалгалтын эрх зүйн орчин бүрдэхэд тус нэмэр болно гэж үзэж байна.

Хяналт шалгалтын үр дүнд торгууль ногдуулах бус, эхлээд зөвлөн туслах шинжтэй албан шаардлага хүргүүлэх нь хяналт шалгалтын байгууллага иргэдэд илүү

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАРИМ ТӨРЛИЙН ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Энэ хуулийн үйлчлэх хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>1.1</sup>-д заасан мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага болон төрийн бусад байгууллагаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийхгүй.

**2 дугаар зүйл.**Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>2</sup> дугаар зүйлд заасан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий байгууллага хийнэ.

**3 дугаар зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан хяналт шалгалтыг хийхдээ үйл ажиллагааг шууд зогсоохоос бусад төрлийн зөрчилд тэргүүн ээлжид албан шаардлага хүргүүлнэ. Албан шаардлага нь зөвлөн туслах, сануулах шинжтэй байна.

**4 дүгээр зүйл.**Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, гааль, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас хийх хяналт шалгалтад энэ хуулийн 1 дүгээр зүйл болон 3 дугаар зүйл хамаарахгүй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйл нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн хяналт шалгалт хийхэд хамаарахгүй.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийн үйлчлэх хугацаа дууссан нь төрийн хяналт шалгалтыг нөхөж хийх үндэслэл болохгүй.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ойр байж, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, туслах, дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг болоход ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн тус хуулийн төслийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, даван туулах зорилгоор түр хугацаанд үйлчлэхээр боловсруулж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7-д Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй гэж заасны дагуу тус хуулийн төсөлд хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх шаардлагагүй гэж үзлээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төсөвт шинээр нэмэгдэх зардал байхгүй.

Хуулийн төсөлд Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайд нараас санал ирүүлсэн байна.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:

“ХХ.ХЭЛЭЛЦСЭН нь: Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР